



**ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 11 ДҮГЭЭР
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 49

Мөрөн сум

**Орон нутгийн хамгаалалттай
газраас хэсэгчлэн чөлөөлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арваннэгдүгээр хуралдаанаас **ТОГТООХ нь:**


1. Сумын орон нутгийн хамгаалалттай газар болох "Өртөө ухаа" нэртэй газрыг хэсэгчлэн чөлөөлж, чөлөөлөх газрын хэмжээг 1-р хавсралтаар, тойм зургийг 2-р хавсралтаар тус тус баталсугай.
2. Орон нутгийн хамгаалалтаас чөлөөлсөн газрыг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын хэлтэст хуулийн хугацаанд бүртгүүлэхийг сумын Засаг дарга /Н.Хатанбаатар/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, Хөдөөгийн хөгжлийн хороо /Н.Амармөрөн/-нд даалгасугай.



D:/Hurliin togtool.doc-2025

231301013

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн
49 дүгээр тогтоолын 1-р хавсралт



**Өртөө ухаа нэртэй газрын тодорхой хэсгийн хэсэгчлэн
чөлөөлөх талбайн хэмжээ, солбилцол**

№	Газрын нэр	Талбайн хэмжээ /га/	Газар зүйн солбилцол		
			№	Уртраг	Өргөрөг
				/X/	/Y/
1	Өртөө ухаа	3.77 га	1	110° 08'50" E	47° 25' 16." N
			2	110° 09'01" E	47° 25' 14" N
			3	110° 09'00" E	47° 25' 09" N
			4	110° 08'50" E	47° 25' 10" N

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн
29 дүгээр тогтоолын 2-р хавсралт

